



БАТЛАВ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ
ТӨРИЙН ГАЗРЫН БИЧГИЙН ДАРГА
З.МЭНДСАЙХАН

**ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД ЯВАГДАХ
“ЭРҮҮЛ АГААР – ЭРЧ ХҮЧ” СПОРТ ЯВГАН АЯЛЛЫН
ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

2017.08.31

Улаанбаатар хот

Нэг. Зорилго

Энэхүү Спорт аяллын тэмцээн нь жил бүр уламжлал болгон зохион явагддаг бөгөөд энэ жилийн тэмцээнийг Эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойг тохиолдуулан ЭХЯ-аас зохион байгуулж байгаагаараа онцлог юм.

Эрчим хүчний салбарын болон эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын ажиллагсад, баг тамирчдыг эх орны түүхийн дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудын цэвэр, цэнгэг агаарт аялуулж, биеийн алжаал, оюуны ядаргааг тайлах, эв нэгдэл, нөхөрлөлийг бэхжүүлэх зорилготой.

Хоёр. Тэмцээний чиглэл, хугацаа

Тэмцээнийг 2017 оны 9 дүгээр сарын 21 - 22-ны өдрүүдэд Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт Цонжин-Болдогт зохион байгуулж явуулна. Тэмцээний нээлтийн ажиллагаа 2017 оны **09** сарын **21** өглөөний 09.00 цагт Улаанбаатар хотод “ДЦС-4” ТӨХК-ийн спортын гадна талбайд болно.

Зохион байгуулагчдын удирдлага дор баг тамирчид өөрсдийн унаандаа сууж нэгдсэн цуваагаар хөдлөх ба Чингис хааны хөшөөт цогцолбороос явган аяллын гарааг эхэлж 20 км яваад отоглох газраа хүрнэ.

Гурав. Тэмцээний заавар

Тэмцээнд 6 хүний бүрэлдэхүүнтэй /2-оос доошгүй эмэгтэй/, багийн бүрэлдэхүүнээс гадна 1 дасгалжуулагчтай баг тамирчид оролцоно.

Тэмцээнийг дараах төрлүүдээр явуулж, төрөл тус бүрд аварга баг, нийт онооны нийлбэрээр тэргүүн байруудыг шалгаруулна.

Жич: Багийн бүрэлдэхүүнд удирдах албан тушаалтан болон горим тооцоо, шуурхай ажиллагааны ажилтан тус бүр 1-ээс доошгүй байна.

Тэмцээний үндсэн төрлүүд

1. Уулын оргил булаалдах
2. Ориентир буюу нуувч илрүүлэх
3. Газрын зураг
4. Спорт буухиа тэмцээн
5. Тамирчдын мэдлэг сорих IQ тэмцээн
6. Азимут /байрлал тогтоох/
7. Унадаг дугуйн буухиаг уралдаан /Монголын дугуйн холбоотой хамтарна/

Нэмэлт оноо өгөх үзүүлэлтүүд

1. Багийн сахилга бат, зохион байгуулалт, /байгууллага дээрээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч баталгаажуулсан хуудас, багийн мэдүүлэг/
2. Тамирчдын хувийн болон багийн бэлтгэл, хувцасны жигдрэлт
3. Отгийн ба галын ариун цэвэр, байгаль хамгаалал
4. Удирдлагын оролцоо /Энэхүү удирдамжийн дөрөв дээр тодотгож тайлбарлав/

Дөрөв. Тэмцээнийг дүгнэх журам, олгох шагнал

Зохиогдсон үндсэн тэмцээний төрөл тус бүрийн аварга багийг тодруулна. Оноо тэнцсэн багуудын байрыг тэргүүн байрны чанарыг харгалзан дүгнэнэ.

Салбарын 95 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан багаа дэмжихээр ирсэн удирдах ажилтнуудаас зохион байгуулах комисст урьдчилан мэдэгдэн хувийн бэлтгэлээ хангаж гараанаас эхлэн цуваатай хамт 8 км алхсанаар зөвхөн нэг хүн нь багтаа дараах нэмэлт оноог авна.

Үүнд: гүйцэтгэх захирал – 3 оноо, дэд захирал – 2 оноо, алба хэлтсийн дарга – 1 оноо. Салбарын удирдлагуудаас аль нэг багийг онцолж дэмжин оролцож болох ба дэмжигчдийн багийг зохион байгуулах комисс болон тэмцээний шүүгчид хамтарч зохицуулна.

Бүх тэмцээний болон дагалдах үзүүлэлтүүд, удирдах албан тушаалтны багт оруулсан хувь нэмэр, техникийн үзлэгийн нийлбэр оноогоор алт, мөнгө, хүрэл медалийн болон тусгай шагналт байрны эздийг тодруулж нэрэмжит шагналыг олгоно.

1-р байр - Цом, Алтан медаль, 1 сая төгрөг

2-р байр - Мөнгөн медаль, 700'000 төгрөг

3-р байр - Хүрэл медаль, 500'000 төг

Тусгай байрын шагнал - 200'000 төг

Тав. Бэлтгэл ажлын талаар

1. Тэмцээнд оролцох байгууллага нь багийнхаа мэдүүлгийг хавсралтад заасны дагуу 2017 оны 09 дүгээр сарын 13-ны дотор тэмцээний комисст munkhchuluun@energy.gov.mn , tsengel@ndc.energy.mn хаягаар ирүүлнэ. /утас 99769696, 99995227, факс 70043467/
2. Тэмцээнд оролцоход гарах зардлыг баг өөрсдөө хариуцна.
3. Багууд нь өөрийн байгууллагын туг /2 : 1 метрийн хэмжээтэй туг, цуваанд авч явахад зориулж байгууллагын лого, багийнхаа нэр зэргийг тусгасан багийн туг, таних тэмдэг, эмблемтэй байна.
4. Багийн болон хувийн бэлтгэлийг бүрэн хангасан байна. Үүнд: багийн хэмжээнд туг, майхан, хоол хүнс, гал тогоо, газрын зураг, луужин, шугам, бал, тооны машин, олс, карабин, хүрз, сүх, модон гадас, эмийн сан, майхнаа тойруулж зурвас байгуулах олс, уяа, дарцагтай байх ба хувийн бэлтгэлд хүн бүр үүргэвч, мышок, гар чийдэн, солих хувцас, оймс зэргийг бэлдсэн байна.
5. 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 15.00 цагт Эрчим хүчний яамны хурлын танхимд багийн дасгалжуулагч болон ахлагчийг оролцуулсан тэмцээний Техникийн зөвлөгөөний хурал хийнэ.

Зургаа. Тамирчдын үзэж сонирхох, отоглох газар

Чингис хааны хөшөөт цогцолбор нь Улаанбаатар хотоос 54 км зайд байгалийн сайхан цогцолсон Туул голын ойролцоо Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Цонжин-Болдог хэмээх түүхэн үйл явдалтай холбоотой газарт байрладаг. Цогцолборын төвд баруун гартаа алтан ташуур тулж наран ургах зүгт алсын бараа харсан 40 метр өндөртэй Чингис хааны морьт хөшөө байрлана.

Чингис хааны хөшөөт цогцолбор нь бүрэн цогцолж дуусах үед эргэн тойронд нь орчин үеийн техник технологийн хөгжлийг харуулсан зочид буудал бүхий 200 гэрүүд байгуулж, гольфын талбай, задгай театр, хиймэл нуур, спортын талбайнууд байгуулан 10 мянган мод тарьсан байна.

Ташуур тулсан дүр бүхий Чингис хааны хөшөөг 250 тонн ган төмрөөр бүтээсэн бөгөөд 13 жилд нэг удаа энэхүү төмөр хуудсыг солих ажээ. Одоохондоо дэлхий дээр байгаа морьт хөшөөнүүдээс хамгийн том нь болсон байна.

Чингис хаан 1177 онд өөрийн дүү Хасар, Бэлгүтэй нарын хамт Хэрэйдийн ван Тоорилд бараалхан булган дээлээ бэлэглэж тусламж эрээд буцаж харих замдаа энэхүү Цонжинболдог толгойгоос нэгэн ташуур олж байсан гэх домог бий. Монгол ёсонд эр хүн ташуур олох нь ерөөл бэлгэдэлтэй үйл явдал бөгөөд сайн учралын дохио хэмээн тайлдаг байна. Тухайн үед Чингис хаан ташуур олсондоо ихэд бэлэгшээж, "ирээдүйн их хэргийн зам нээгдлээ" хэмээн айлдсан ажээ. Хожим түүхчид энэхүү ерөөл үгийг нь "Энэ үйл явдал бол толгойтныг бөхийлгөн, тойгтныг сөхрүүлэн дэлхийн талыг байлдан дагуулах их үйл хэрэгт нь ташуур нэмсэн бэлгэдэлтэй сайн үйл хэрэг болжээ" хэмээн тайлбарласан байдаг.

Хөшөөний суурийн хэсэгт аравнайлсан алтан ташуур, уран зургийн галарей, үзвэрийн танхим, зоогийн газар, хурлын танхим, уулзалтын өрөө, биллиард өрөө, бэлэг дурсгалын дэлгүүр зэрэг байрладаг.

Чингис хааны хөшөөт цогцолбороос Бурхан халдун уул, Дэлүүн болдог толгой, Хөдөө арал гэх мэт Чингис хааны түүхтэй холбоотой чухал дурсгалт газрууд харагддаг байна.

Спорт явган аяллын энэхүү тэмцээний талаарх мэдээллийг www.hiking.energy.mn вэб сайтаас үзэх боломжтой ба тэмцээний зохион байгуулалттай холбоотой асуудлаар Б.Мөнхчулуун 99769696, Ж.Батбилэг 99071928, тэмцээн уралдаантай холбоотой асуудлаар Б.Бямбажав 99196917, Г.Мөнхцоодол 99083956 утсаар холбоо барина уу.